“AstraZeneca” компанийн вакцины зориулалтад (2021 оны9 сар)

Коронавирусын эсрэг вакциныг хэрэглэх заавар

(Эхний удаа хийлгэх (1-р тун, 2-р тун хийлгэх)

◎ **Шаардлагатай тохиолдлоос бусад үед уг вакциныг үндсэндээ 40 ба түүнээс дээш насныхан хэрэглэнэ.**

◎ **Гэвч шинэ төрлийн коронавирусын бусад вакцины найрлагад орсон бодисоос харшилдаг гэх мэт вакцин хийлгэх боломжгүй зэрэг зөвхөн “AstraZeneca” компанийн вакцин хийлгэх хүсэлтэй байгаа тохиолдолд 18-аас 40 хүртэлх насныхан ч тариулж болно.**

◎ **Гадаадад маш ховор тохиолдолд тромбоцитопени бүхий тромбоз, хялгасан судасны нэвчилтийн хам шинж, гуилайн-баррегийн хам шинж зэрэг демиелинат (demyelinating)-ын өвчин илэрч байгааг мэдээлсэн. Вакцин хийлгэхдээ үүсэх эрсдэл болон давуу талыг ойлгож, хүлээн зөвшөөрсний үндсэн дээр хийлгэнэ үү.**

Коронавирусын эсрэг вакцины тухай

Энэхүү вакцин нь үндэсний болон орон нутгийн засаг захиргааны коронавирусын (SARS-CoV-2) эсрэг вакцинжуулалтын хөтөлбөрийн нэг хэсэг юм. Энэхүү вакцинжуулалтыг Засгийн санхүүжүүлж байгаа бөгөөд хүссэн хүн бүр үнэ төлбөргүй хамрагдах боломжтой. Энэхүү вакцин нь 12 ба түүнээс дээш насны хүмүүст зориулагдсан.

Вакцины үр нөлөө, ашиглах арга

Энэ вакцин нь “AstraZeneca” компанийн вакцин ба шинэ төрлийн коронавирусын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлнэ.

Вакцинд хамрагдсан хүмүүс хамрагдаагүй хүнтэй харьцуулахад шинэ төрлийн коронавирусын халдварт өвчнөөр өвдөх нь бага хэмээн тогтоогдсон. (Эмнэлзүйн туршилтаар урьдчилан сэргийлэх үр нөлөөний 70 орчим хувь нь батлагдсан болно.)

Худалдааны нэр	Vaxzevria™ булчинд тарих
Үр нөлөө	SARS-CoV-2-ээс үүдэлтэй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
Вакцинжуулалтын давтамж ба хоорондын зай	2 удаа (ихэвчлэн 4-12 долоо хоногийн зайтай) * Булчинд тарих
Вакцинжуулалтын хамрах хүрээ	40 ба түүнээс дээш насныханд
Тарилгын тоо, тун	Нэг тун 0.35 мл-ээр нийт 2 удаа

- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай зөвшөөрөлд эхний тунг хийлгэснээс хойш ойролцоогоор 4-12 долоо хоногийн зайтай 2 дахь хийлгэнэ гэж заасан байна. Гэвч доод тал нь 8 долоо хоногоос дээш хугацааны дараа хийлгэвэлзохилтой гэж үзэж байна. Мөн эхний тунгаас хойш 12 долоо хоног өнгөрсөн бол хоёр дахь тунгаа аль болох хурдан тариулна уу.
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай зөвшөөрөлд вакцинжуулах зорилтот насыг 18 ба түүнээс дээш насныханд үр дүнтэй, аюулгүй гэж үзсэн боловч, бусад улс оронд зөвлөмж болгож буй хэрэглээний нөхцөл байдал болон бүх насныханы эрсдэл, давуу талуудтай холбоотой мэдээллийг харгалзан одоогийн байдлаар 40 ба түүнээс дээш насныханд зориулан хийж байна.
- Хэрэв та эхний тундаа энэ вакциныг хийлгэсэн бол зарчмын хувьд хоёр дахь тундаа энэ вакциныг хийлгээрэй.
- Эмнэлзүйн туршилтаар тус вакцины хоёр дахь тунг хийснээс хойш ойролцоогоор 15 хоногийн дараа хангалттай дархлаа тогтож байгааг тогтоосон байна. Мөн халдвараас бүрэн хамгаална гэсэн үг биш юм. Вакцинд хамрагдсан эсэхээс үл хамааран халдвараас урьдчилан сэргийлэх зохистой арга хэмжээг авах шаардлагатай.

Вакцинжуулалтад хамрагдах боломжгүй хүн

Энэ вакциныг доорхи хүмүүст хийх боломжгүй. Вакцин хийлгэхээс өмнөх үлэгийн үед доорхи нөхцлүүд танд хамаатай гэж бодож байвал эмчид заавал мэдэгдэнэ үү.

- Илт халуурах шинж тэмдэгтэй хүн (*1)
- Хүнд цочмог өвчтэй хүн
- Энэ вакцины аль ч орцонд хэт их мэдрэг (*2) өвчний түүхтэй хүн
- SARS-CoV-2 вакциныг хийлгэсний дараа тромбоцитопени бүхий венийн болон артерийн тромбоз үүссэн хүн
- Хялгасан судасны нэвчилтийн хам шинжтэй байсан хүн
- Дээрхээс гадна вакцин хийлгэхэд биеийн байдал тохиромжгүй хүн.

(*1) 37.5℃ ба түүнээс дээш халуурч байвал илт халуурах шинж тэмдэгтэй гэж тодорхойлно. Гэвч, 37.5℃ -ээс бага халуурч байсан ч энгийн үеийн биеийн халуунаас их байвал халуурч байна гэж үзнэ.

(*2) Анафилаксийн шок болон бүх биеийг хамарсан арьс, салстан бүрхэвчээр туурах, амьсгаадах, амьсгал давчдах, зүрхний хэм алдагдах, цусны даралт буурах зэрэг харшлын шинж тэмдэг орно.

Вакцин хийлгэхдээ анхаарах хэрэгтэй хүн

Дараах шинж тэмдэг илэрдэг хүмүүс энэ вакциныг хийлгэхдээ анхаарах хэрэгтэй. Вакцин хийлгэхээс өмнөх үзлэгийн үед доорхи шинж тэмдэг танд хамаатай гэж бодож байвал эмчид заавал мэдэгдэнэ үү.

- Антикоагулянт эмчилгээ хийдэг, тромбоцитопени буюу цус бүлэгнэлтийн эмгэгтэй
- Өмнө нь дархлал хомсдол гэж оношлогдсон, эсвэл төрөл төрөгсөд нь удмын дархлал хомсдолын өвчтэй хүн байгаа бол
- Зүрх, бөөр, элэг, цус, хөгжлийн гажиг зэрэг суурь өвчтэй
- Өмнө нь вакцин хийлгэсний дараа 2 хоногийн дотор харшлын шинж тэмдэг, тухайлбал халуурах, тууралт гарах зэрэг шинж тэмдгүүд илэрч байсан бол
- Таталт өгдөг, өгч байсан бол
- Тус вакцины найрлагад харшилтай байж болзошгүй бол

(Ар талд үргэлжлэл бий)

Хэрэв та жирэмсэн эсвэл жирэмсэн байж болзошгүй, эсвэл хөхүүл хүүхэдтэй бол вакцин хийлгэхээс өмнө эмчид заавал мэдэгдэнэ үү

Энэ бүтээгдэхүүн нь урьд өмнө байгаагүй нэмэлт бодис агуулдаг. Хэрэв та өмнө эмэнд хэт мэдрэг эсвэл харшлын урвал үзүүлж байсан бол урьдчилсан үзлэгийн үеэр энэ талаар эмчид заавал мэдэгдэнэ үү

Вакцин хийлгэсний дараа анхаарах зүйлс

- Вакцинаа хийлгэсний дараа доод тал нь 15 минут хүлээнэ үү (өмнө нь харшлын шинж тэмдэг, түүний дотор анафилаксийн шок гэх мэт хүнд хэлбэрийн өвчнөөр өвчилж байсан, эсвэл бие тавгүйрхэж, ухаан алдаж унаж байсан гэх мэт хүн дор хаяж 30 минут хүлээнэ үү). Хэрэв бие тавгүйрхвэл эмчид яаралтай хандах хэрэгтэй. (Энэ нь гэнэтийн хариу урвалд яаралтай арга хэмжээ авах боломжийг олгоно.)
- Тарилга хийх хэсэг цэвэр байх ёстой. Хэдийгээр та вакцин хийлгэсэн өдөр усанд орж болох ч тарилга хийсэн хэсгийг үрж угааж болохгүй.
- Жирийн амьдралын хэв маягаа үргэлжлүүлж болох ч тухайн өдөр хүчтэй дасгал хөдөлгөөн хийх, согтууруулах ундаа хэтрүүлж хэрэглэхээс зайлсхийнэ үү.

Гаж нөлөө

- Гаж нөлөөнд голчлон тариулсан газар өвдөх, толгой өвдөх, үе мөч болон булчин өвдөх, сульдах, ядрах, хүйт оргих, халуурах зэрэг орно. Гэвч эмнэлзүйн туршилтаар эдгээр шинж тэмдгүүд нь хоёр дахь тун хийхээс илүү эхний тунг хийхэд үүсэх магадлал өндөртэй гэж үзэж байна. Мөн ховор тохиох ноцтой гаж нөлөөнд шок эсвэл анафилаксийн шок орно. Одоогийн вакцин нь шинэ төрлийн вакцин тул хараахан тодорхой болоогүй шинэ шинж тэмдэг илэрч болзошгүй юм. Хэрэв вакцин хийлгэсний дараа ямар нэг шинж тэмдэг илэрвэл вакцинжуулагч эмч эсвэл хариуцсан эмчтэй холбоо бариарай.
- Маш ховор тохиолдолд вакцин хийлгэсний дараа тромбоцитопени бүхий тромбоз (*1), хялгасан судасны нэвчилтийн хам шинж (*2), гуилайн-баррегийн хам шинж зэрэг демиелинат (demyelinating)ын өвчин (*3) илэрсэн тохиолдлыг гадаадад мэдээлсэн. Вакцин хийлгэсний дараа доорхи шинж тэмдэг илэрвэл яаралтай эрүүл мэндийн байгууллагад хандаарай.

(*1) Толгой тасралтгүй хүчтэй өвдөх, нүд бүрэлзэх, амьсгал давчдах, уймрах, таталт өгөх, цээж өвдөх, хөл хавагдах болон өвдөх, хэвлийгээр тасралтгүй өвдөх, тариулсан хэсгийн гадна талд цус хурах (хөхрөх) зэрэг шинж тэмдэг. Гэвч эдгээр шинж тэмдгийн ихэнх нь вакцин хийлгэснээс хойш 28 хоногийн дотор үүсэх нь их бөгөөд, мөн 2 дахь тунг хийлгэхээс илүү эхний тунг хийлгэсний дараа үүсэх нь их байдаг.

(*2) Гар хөл хавагнах, цусны даралт буурах зэрэг шинж тэмдэг.

(*3) Гар хөлөө хөдөлгөхөд хэцүү болох зэрэг хөдөлгөөний бэрхшээл, мэдээ алдах зэрэг мэдрэхүйн бэрхшээл, бие засахад хүндрэл учрах, нүд бүрэлзэх зэрэг харааны бэрхшээл.

Вакцины эрүүл мэндэд үзүүлэх хор хөнөөлийг бууруулах системийн талаар

Вакцинжуулалт нь эрүүл мэндийн асуудал (өвчин, хөгжлийн бэрхшээл) үүсгэх магадлалтай. Энэ нь нэн ховор боловч эрсдлийг арилгах боломжгүй юм. Тиймээс тусламжийн системийг бий болгосон.

Коронавирусын эсрэг вакцины улмаас эрүүл мэнд хохирсон тохиолдолд дархлаажуулалтын тухай хуулийн дагуу тусламжийг (эмчилгээний зардал, тахир дутуугийн тэтгэвэр гэх мэт) олгогдоно. Өргөдөл өгөх талаар оршин суугаа хотын захиргаанаасаа лавлана уу.

Коронавирусын халдварын тухай

SARS-CoV-2 халдварын үед шинж тэмдгүүд нь халуурах, ханиалгах зэрэг нийтлэг ханиадны шинж тэмдгүүдтэй төстэй байдаг. Ихэнх хүмүүс тус өвчний хөнгөн шинж тэмдгээр тусаж эдгэрдэг боловч хүнд тохиолдолд амьсгал давчдах зэрэг уушгины хатгалгааны шинж тэмдэг илэрч, нөхцөл байдал улам муудаж, улмаар үхэлд хүргэх аюултай.

Коронавирусын вакцины тодорхойлолт (AstraZeneca компанийн вакцин)

Уг вакцин нь вирус вектор вакцин бөгөөд SARS-CoV-2 холболтын үндсэн уураг (вирус хүний эсэд нэвтрэх шаардлагатай уураг) -ын амин хүчлийн дараалыг кодлодог генийг саладено вирус (ханиадны вирус болох аденовирусд үржихээс сэргийлсэн арга хэмжээг авдаг)-д агуулсан бүтээгдэхүүн юм. Энэ вакцинаар генийг хүний эсэд оруулахад генийн үндсэн дээр эсүүдэд вирусын холболтын уурийг саармагжуулах эсрэг биет болон эсийн дархлааны хариу урвалын эсрэг биетүүдийг үүсгэдэг бөгөөд энэ нь SARS-CoV-2-ийн халдвараас урьдчилан сэргийлдэг гэж үздэг.

Энэхүү эмийн хэрэгсэл нь дараах найрлагатай

Идэвхтэй найрлага	✧ Коронавирус (SARS-CoV-2) вакцин (генийн шинэ хослолыг үүсгэх саладено вирусын вектор) (Анхаар: SARS-CoV-2-ын холболтын үндсэн уургийн амино хүчлийн дараалыг кодлодог генийг агуулсан саладено вирус)
Нэмэлт	✧ L-гистидин ✧L-гистидин гидрохлоридын гидрат ✧ Натри хлорид ✧Магни хлорид ✧ Эдетат натри гидрат ✧Сахароз ✧ Усгүй этэнол ✧Полисорбат 80

Коронавирусын эсрэг вакцины үр нөлөө, аюулгүй байдлын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны вэбсайт дахь Шинэ төрлийн коронавирусын вакцин хуудаснаас үзнэ үү.

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, коронавирусын эсрэг шинэ вакцин | Хайх

Хэрэв та вэбсайтаа үзэх боломжгүй бол хотын захиргаатай холбоо бариарай.